



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 4 сарын 12 өдөр

Дугаар 76

Улаанбаатар хот

“Уужимхангай” ХК-д “Стандарт  
агрикалчер групп” ХХК-ийг нэгтгэхийг  
зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.10, Компанийн тухай хуулийн 20 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Уужимхангай” ХК-ийн гаргасан нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 136,487 /нэг зуун гучин зургаан мянга дөрвөн зуун наян долоо/ ширхэг хувьцааг тус компанид нэгдэж буй “Стандарт агрикалчер групп” ХХК-ийн нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 13,599,265 /арван гурван сая таван зуун ерэн есөн мянга хоёр зуун жаран тав/ ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлэн нийт нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 13,735,752 /арван гурван сая долоон зуун гучин таван мянга долоон зуун тавин хоёр/ ширхэг хувьцаа болгон нийтэд санал болгохыг зөвшөөрснийг үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Т.Цэрэнбадрал/-т үүрэг болгож, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “ҮЦТХТ” ХХК /Ш.Лхагва/-д зөвшөөрсүгэй.

2. Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт орсонтой холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Уужимхангай” ХК /Б.Цэрэн-Очир/-д үүрэг болгосугай:

1/ “Уужимхангай” ХК-д “Стандарт агрикалчер групп” ХХК-ийг нэгтгэх зөвшөөрөл олгосонтой холбоотойгоор “Уужимхангай” ХК-ийн хувьцаа эзэмшигчид өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхийг хуульд заасан журмын дагуу хэрэгжүүлэх;

2/ “Уужимхангай” ХК-д “Стандарт агрикалчер групп” ХХК-ийг нэгтгэсэнтэй холбогдуулан хууль тогтоомжид заасны дагуу компанийг өөрчлөн байгуулах, нэгдэж байгаа компанийн өмчлөлийн хөрөнгийг “Уужимхангай” ХК-д шилжүүлэх, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн, шинэчилсэн дүрмийг хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлж, Санхүүгийн зохицуулах хороонд холбогдох баримт бичгийн хамт ирүүлэх;

3/ 2017 оны хоёрдугаар улирлын санхүүгийн тайланд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд орсон өөрчлөлтийг тусгах;

4/ Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйл болон Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 443 дугаар тогтоолоор баталсан "Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам"-д заасан мэдээллийг тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллах;

00161

5/ Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 162 дугаар тогтоолоор баталсан “Компанийн засаглалын кодекс”-ыг үйл ажиллагаандаа чанд баримталж, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалж ажиллах.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц /-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН